



**ОЛОН УЛСЫН УЛААНБААТАРЫН
ИХ СУРГУУЛЬ**

РЕКТОРЫН ТУШААЛ

2025 он 12 сар 05 өдөр

Дугаар А/135

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай


ОУУБИС-ийн Захиргааны зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. “ОУУБИС-ийн цахим шуудан, сургалтын үйл ажиллагаанд Гүүгл (Google), Микрософт (Microsoft)-ын боловсролын лицензтэй программ ашиглуулах журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Журам шинэчлэн батлагдсантай холбогдуулан ОУУБИС-ийн Ерөнхий захирлын 2020 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн А/42 тоот тушаалаар батлагдсан “ОУУБИС-ийн цахим шуудангийн үйлчилгээний журам”-ыг хүчингүйд тооцсугай.
3. Боловсролын багц үйлчилгээг ашиглаж байгаатай холбоотой лицензийн бодлого, зарчим, ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөхийг нийт профессор багш, ажилтан, оюутан суралцагчдад үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сургалтын алба (Б.Туяа), Магистр, докторын алба (Б.Сүх-Очир) нарт үүрэг болгосугай.

РЕКТОР



КАН ЮУ ЁЛЬ



ОУУБИС-ийн цахим шуудан, сургалтын үйл ажиллагаанд
Гүүгл (Google), Микрософт (Microsoft)-ын боловсролын лицензтэй
программ ашиглуулах журам

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Энэ журмаар Олон Улсын Улаанбаатарын Их Сургуулийн (цаашид "ОУУБИС" гэх) оюутан, профессор багш, ажилтан буюу сургалтын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байгаа хэрэглэгчдэд Гүүгл (Google Workspace for Education Fundamentals), Микрософт (Microsoft 365 Education-A1)-ын боловсролын лиценз олгох, программ, үйлчилгээ үзүүлэх харилцааг зохицуулна.
- 1.2. Гүүгл (Google), Микрософт (Microsoft)-ын боловсролын багц үйлчилгээг ашиглахтай холбоотой лицензийн бодлого, зарчим, ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө.
- 1.3. Энэ журмыг ОУУБИС-ийн нийт оюутан, профессор багш, ажилтан дагаж мөрдөнө.

ХОЁР. ЛИЦЕНЗ АШИГЛУУЛАХ, ЦУЦЛАХ ТУХАЙ

- 2.1. ОУУБИС-ийн профессор багш, ажилтан, бакалаврын түвшинд суралцаж байгаа оюутнуудад ulaanbaatar.edu.mn домайн нэр бүхий албан хаягаар Гүүгл (Google)-ийн боловсролын лицензтэй программ хангамж, үйлчилгээг ашиглах эрх олгоно.
- 2.2. ОУУБИС-ийн ахисан түвшний оюутнууд, ахисан түвшний сургалтад хичээл заах доктор багш, ахисан түвшний сургалтад оролцож байгаа ажилтнуудад iuu.edu.mn домайн нэр бүхий албан хаягаар Микрософт (Microsoft)-ын боловсролын лицензтэй программ хангамж, үйлчилгээг ашиглах эрх олгоно.
- 2.3. Шинээр элсэн орсон оюутан, шинээр ажилд орсон профессор багш, ажилтанд ОУУБИС-ийн Ректорын элсэн орсон болон ажилд орсон тухай тушаалыг үндэслэн лицензтэй программ хангамж, үйлчилгээг ашиглах эрхийг мэйл хаягаар дамжуулан олгоно.
- 2.4. Жилийн чөлөө авсан, тухайн улиралд хичээл сонголтоо баталгаажуулаагүй оюутны нэвтрэх эрхийг түр хаана.
- 2.5. ОУУБИС-ийн Ахисан түвшний сургуулийн ашиглаж буй Клауд университ (Cloud University) болон бакалаврын түвшинд ашиглаж буй Коллеж менежмент систем (CMS)-д төгссөн төлөвтэй оюутны хаягийг 15 хоногийн дараа нэвтрэх эрхийг хааж, 30 хоногийн дараа лицензийн эрхийн бүртгэлийг системээс устгана.
- 2.6. Хөдөлмөрийн гэрээ цуцлагдсан профессор багш, ажилтан, цаашид суралцахаас татгалзсан (сургуулиас гарах, шилжих гэх мэт) оюутны лицензийн эрхийг ОУУБИС-ийн Ректорын тушаал, Захиргаа, хүний нөөцийн албанаас ирүүлснээр тасалбар болгож 15 хоногийн дараа нэвтрэх эрхийг хааж, 30 хоногийн дараа лицензийн эрхийн бүртгэлийг системээс устгана.
- 2.7. Зарим захиргааны албан тушаалтны хаягийг орсон гарсан тушаалыг үндэслэн дараагийн албан тушаалтанд шууд шилжүүлэх бүртгэлийг системд хийх ба энэ тохиолдолд хоног тооцохгүй.
- 2.8. Чөлөө авах, сургуулиас гарах тухайгаа бичгээр хүсэлт гаргаагүй сураггүй болсон ахисан түвшний оюутны хаягийг Клауд университ (Cloud University), бакалаврын түвшний оюутны хаягийг Коллеж менежмент систем (CMS)-ийн бүртгэлийг үндэслэн системээс шууд устгана.

- 2.9. Цагийн болон гэрээт багш нарт мөн хамаарах бөгөөд дараагийн улиралд хичээл заахгүй бол нэвтрэх эрхийг хаах, системээс шууд устгах зохицуулалт хийнэ.
- 2.10. Лицензийн эрхийг цуцлах тухай сануулах мэйлийг төгссөн, сургуулиас гарсан оюутан болон хөдөлмөрийн гэрээ дуусгавар болсон профессор багш, ажилтанд илгээнэ.

ГУРАВ. ОЮУТНЫ ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1. ОУУБИС-д идэвхтэй суралцаж байгаа бакалаврын түвшний оюутан Гүүгл (Google)-ийн, ахисан түвшний оюутан Микрософт (Microsoft)-ын боловсролын лиценз ашиглах эрхтэй байна.
- 3.2. Оюутан тухайн программ хангамж, үйлчилгээний эрхтэй холбоотой асуудлаар системийн админ, бүртгэл хариуцсан ажилтнаас заавар, зөвлөмжийг ойлгомжтой байдлаар авах эрхтэй.
- 3.3. Зөвшөөрөгдсөн программ хангамж, үйлчилгээг ашиглахдаа, тухайлбал зар сурталчилгааны чанартай, бусдад хүндэтгэлгүй хандсан, ёс бус үг хэллэг агуулсан мэйл илгээхгүй байвал зохино.
- 3.4. Оюутан албан хаягийнхаа нууц үгийг бусдад алдахгүй байх, хүчтэй нууц үг эсвэл 2FA, MFA ашиглах, нууц үгээ алдсаны улмаас гарсан аливаа асуудлыг өөрөө хариуцна.
- 3.5. Аливаа хувь хүн, байгууллагад албан хаягийг мэдэгдэхдээ ямар зорилгоор ашиглах тухай мэдээлэлтэй байх шаардлагатай бөгөөд тодорхойгүй цахим хуудас, асуулга, системд албан хаягаар бүртгүүлж үл болно.
- 3.6. Лицензийн эрхийг цуцлах тухай 2.4, 2.5, 2.6, 2.8-д заасан хугацаанд үүлэн хадгалах (Google Drive, OneDrive) дээр хадгалагдсан өөрийн мэдээлэл, өгөгдөл, баримтыг өөрийн локаль диск, эсвэл хувийн хаяг руугаа шилжүүлэн авна. Хэрэв тухайн хугацаанд өөрийн мэдээлэл, өгөгдөл, баримт зэргийг шилжүүлэн аваагүйгээс журамд заасан хугацаанд устсан тохиолдолд гарах аливаа асуудлыг сургууль, системийн админ, бүртгэл хариуцсан ажилтан хариуцахгүй.

ДӨРӨВ. ПРОФЕССОР БАГШ, АЖИЛТНЫ ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1. ОУУБИС-ийн профессор багш, ажилтан Гүүгл (Google)-ийн боловсролын лиценз ашиглах, ахисан түвшний сургалтад хичээл заах профессор багш Микрософт (Microsoft)-ын боловсролын лицензийн эрхийг заавал, бусад багш ажилтан хүсвэл Микрософт (Microsoft)-ын боловсролын лицензийн эрх эзэмшиж болно.
- 4.2. Зөвшөөрөгдсөн программ хангамж, үйлчилгээг ашиглахдаа, тухайлбал зар сурталчилгааны чанартай, бусдад хүндэтгэлгүй хандсан, ёс бус үг хэллэг агуулсан мэйл илгээхгүй байх зарчмыг баримтална.
- 4.3. Профессор багш, ажилтан албан хаягийнхаа нууц үгийг бусдад алдахгүй байх, хүчтэй нууц үг эсвэл 2FA, MFA ашиглах бөгөөд нууц үгээ алдсаны улмаас гарсан аливаа асуудлыг биечлэн хариуцна.
- 4.4. Аливаа хувь хүн, байгууллагад албан хаягийг мэдэгдэхдээ ямар зорилгоор ашиглах тухай мэдээлэлтэй байх шаардлагатай бөгөөд тодорхойгүй цахим хуудас, асуулга, системд албан хаягаар бүртгүүлж үл болно.
- 4.5. Лицензийн эрхийг цуцлах тухай 2.6, 2.7, 2.9-д заасан хугацаанд үүлэн хадгалах (Google Drive, OneDrive) дээр хадгалагдсан өөрийн мэдээлэл, өгөгдөл, баримтыг өөрийн локаль диск, эсвэл хувийн хаяг руугаа шилжүүлэн авна. Хэрэв тухайн хугацаанд өөрийн мэдээлэл, өгөгдөл, баримтыг шилжүүлэн аваагүйгээс журамд заасан хугацаанд устсан тохиолдолд гарах аливаа асуудлыг сургууль, системийн админ, бүртгэл хариуцсан ажилтан хариуцахгүй.
- 4.6. Профессор багш, ажилтан тухайн программ хангамж, үйлчилгээний эрхтэй холбоотой асуудлаар системийн админ, бүртгэл хариуцсан ажилтнаас заавар, зөвлөмжийг ойлгомжтой байдлаар авах эрхтэй.

ТАВ. БУСАД

- 5.1. Гүүгл (Google), Микрософт (Microsoft)-ын системийн тохиргоо, засвар үйлчилгээг хариуцсан системийн админ нь мэдээллийн технологийн мэргэжилтэй байх ба Гүүгл (Google)-ийн бүртгэлийг бакалаврын сургалтын алба, Микрософт (Microsoft)-ын бүртгэлийг магистр, доктор оюутны сургалтын албаны мэргэжилтэн хариуцна.
- 5.2. Гүүгл (Google), Микрософт (Microsoft)-ын бодлогын хүрээнд ОУУБИС-ийн бүтцийг системд зурж, түүний дагуу хэрэглэгчийг бүртгэх, лицензийн эрхийг хаах, цуцлах асуудлыг эмх цэгцтэй, журамд зааснаар явуулах үүргийг системийн админ, бүртгэлийн ажилтнууд хариуцна.
- 5.3. Системд гарахаар төлөвлөж байгаа эсвэл гарсан аливаа өөрчлөлтийг цаг тухай бүр хэрэглэгчдэд хүргэх үүргийг системийн админ, бүртгэлийн ажилтнууд хариуцна.
- 5.4. Гүүгл (Google)-ийн боловсролын системийн хэрэглэгчийн бүртгэл, форматтай холбоотой асуудлыг Хавсралт 1-ээр зохицуулна.
- 5.5. Микрософт (Microsoft)-ын боловсролын системийн хэрэглэгчийн бүртгэл, форматтай холбоотой асуудлыг Хавсралт 2-оор зохицуулна.
- 5.6. Профессор багш, оюутан, ажилтнууд ОУУБИС-ийн бүтэц, ажил үүрэгтэй холбоотой группт бүртгэлтэй байна. Гадаад, дотоод харилцаанд зориулсан нэгжийн нэр бүхий албан хаягийг зөвхөн Ректорын ажлын алба, Сургалтын алба, Оюутны алба зэрэг нэгжүүдэд зөвшөөрнө.

Гүүгл (Google)-ийн боловсролын лицензийн бүртгэлийн формат

Бакалаврын оюутан

Лицензийн эрх бүхий мэйл хаягт агуулагдах мэдээлэл

- ✓ First name (Нэр-латин үсгээр галиглаж бичнэ)
- ✓ Last name (Овог-латин үсгээр галиглаж бичнэ)
- ✓ Photo (Профайл зураг-1x1 харьцаатай цээж зураг)
- ✓ Phone number (Утасны дугаар-идэвхтэй хэрэглэдэг дугаар)
- ✓ Username (CMS системд бүртгэлтэй оюутны код)
- ✓ Password (тэмдэгт, цифр, Том, жижиг латин үсгээс бүрдсэн 8-аас доошгүй урттай)

Лицензийн эрх бүхий мэйл хаягийн формат

Username	dot	@	Domain	dot	Education	dot	Mongol
gd23d008	.	@	ulaanbaatar	.	edu	.	mn

Лицензийн эрх бүхий Гүүгл (Google) хаяг

gd23d008@ulaanbaatar.edu.mn

Гүүгл (Google)-ийн хэрэглээний программын дэлгэц дээр харагдах байдал



Профессор багш, ажилтан

Лицензийн эрх бүхий мэйл хаягт агуулагдах мэдээлэл

- ✓ First name (Нэр-латин үсгээр галиглаж бичнэ)
- ✓ Last name (Овог-латин үсгээр галиглаж бичнэ)
- ✓ Photo (Профайл зураг-1x1 харьцаатай цээж зураг)
- ✓ Phone number (Утасны дугаар-идэвхтэй хэрэглэдэг дугаар)
- ✓ Username (нэр, овгийн эхний 1-2 үсэг латинаар галигласан байна)
- ✓ Password (тэмдэгт, цифр, Том, жижиг латин үсгээс бүрдсэн 8-аас доошгүй урттай)

Лицензийн эрх бүхий мэйл хаягийн формат

Username	dot	@	Domain	dot	Education	dot	Mongol
tulga.a	.	@	ulaanbaatar	.	edu	.	mn

Лицензийн эрх бүхий Гүүгл (Google) хаяг

tulga.a@ulaanbaatar.edu.mn

Гүүгл (Google)-ийн хэрэглээний программын дэлгэц дээр харагдах байдал



Микрософт (Microsoft)-ын боловсролын лицензийн бүртгэлийн формат

Магистр, доктор оюутан

Лицензийн эрх бүхий мэйл хаягт агуулагдах мэдээлэл

- ✓ First name (Нэр-латин үсгээр галиглаж бичнэ)
- ✓ Last name (Овог-латин үсгээр галиглаж бичнэ)
- ✓ Photo (Профайл зураг-1x1 харьцаатай цээж зураг)
- ✓ Phone number (Утасны дугаар-идэвхтэй хэрэглэдэг дугаар)
- ✓ Username (Cloud University системд бүртгэлтэй оюутны код)
- ✓ Password (тэмдэгт, цифр, Том, жижиг латин үсгээс бүрдсэн 8-аас доошгүй урттай, 2FA)

Лицензийн эрх бүхий мэйл хаягийн формат

Username	dot	@	Domain	dot	Education	dot	Mongol
e233031	.	@	iuu	.	edu	.	mn

Лицензийн эрх бүхий Микрософт (Microsoft)-ын хаяг

e233031@iuu.edu.mn

Микрософт (Microsoft)-ын хэрэглээний программын дэлгэц дээр харагдах байдал



Azjargal Lkhavadorj

e233031@iuu.edu.mn

Профессор багш, ажилтан

Лицензийн эрх бүхий мэйл хаягт агуулагдах мэдээлэл

- ✓ First name (Нэр-латин үсгээр галиглаж бичнэ)
- ✓ Last name (Овог-латин үсгээр галиглаж бичнэ)
- ✓ Photo (Профайл зураг-1x1 харьцаатай цээж зураг)
- ✓ Phone number (Утасны дугаар-идэвхтэй хэрэглэдэг дугаар)
- ✓ Username (нэр, овгийн эхний 1-2 үсэг латинаар галигласан байна)
- ✓ Password (тэмдэгт, цифр, Том, жижиг латин үсгээс бүрдсэн 8-аас доошгүй урттай)

Лицензийн эрх бүхий мэйл хаягийн формат

Username	dot	@	Domain	dot	Education	dot	Mongol
badamkhand	.	@	iuu	.	edu	.	mn

Лицензийн эрх бүхий Микрософт (Microsoft) хаяг

badamkhand@iuu.edu.mn

Микрософт (Microsoft)-ын хэрэглээний программын дэлгэц дээр харагдах байдал



Badamkhand Yundendorj

badamkhand@iuu.edu.mn